**УЛААНБААТАР**
**ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙ**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 08 өдөр          Дугаар А/70          Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Компаний дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг салбар, нэгж, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Д.Баатарням/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ          Д.БАЯРСАЙХАН

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ”
ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 05
дугаар сарын 08-ний өдрийн А/130 дугаар
тушаалын хавсралт

# “УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төлөвлөгөөг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ. Байгууллагын авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамаарах ажлуудыг төлөвлөв. Төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуультай уялдуулав.

| /д | Үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндэслэл | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэг-жүүлэх хугацаа, хуваарь | Хариуцах нэгж, албан тушаалтан | Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:** | | | | | |
| .1 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, журам, дүрмийн төсөлд ажилчдын болон сонирхогч бүлгийн саналыг тусгах арга хэмжээ авах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | - Төсөлд ажилчид болон сонирхогч бүлгээс санал өгөх боломжоор хангах,<br>- Ил тод байршуулах техникийн нөхцлийг бүрдүүлсэн байх,<br>- Төслийн талаарх ажилчид болон бусад этгээдээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах,<br>- Эрх бүхий этгээдээр батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах. | Тухай бүрд | Тухайн холбогдох салбар, нэгж, хэлтэс, алба | МТХ,<br>Бүх салбар, нэгж, хэлтэс, алба, |
| .2 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх | - Хуулийн холбогдох заалтыг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн байх,<br>- Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх, | V-XII сар | Ц.Энхцэцэг, | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9. | - Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцын талаарх мэдээлэл ил тод болсон байх.<br>- Шилэн дансны мэдээллийн ил тод байдалд хангаж ажилласан байх. | | Б.Батцэцэг, Г.Пүрэвдорж, З.Энх-Оргил, Д.Ганбаяр /2016 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/15 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хамаарна/ | |
| 3 | Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, албан хаагчдад мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажиллах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | - www.able.mn дотоод сүлжээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт албан хаагчдын хэрэгцээний мэдээллийг шуурхай байршуулан мэдээлж байх,<br>- Дотоод сүлжээний системийг иж бүрнээр нь ашиглаж хэвшүүлэх. | V-XII сар | Г.Ган-Өлзий | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |
| .4 | Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, мэдээллийн ил тод байдлыг хангах боломжийг бий болгох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | - Байгууллагын цахим хуудас хэвийн ажиллагаатай болсон байх,<br>- Бүх салбар нэгж, хэлтэс, албадуудын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байх,<br>- Мэдээллийн баяжилт хийгдсэн байх. | V-VII сард | Г.Ган-Өлзий | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |
| .5 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | - Мэдээлэл нээлттэй, үр ашигтай, хүртээмжтэй байх,<br>- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааны явцыг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшсэн байх,<br>- Байгууллагын цахим хуудас болон холбогдох бусад цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулсан байх,<br>- Байгууллагын цахим хуудасны | V-XII сар | Цэнгэлмаа, Г.Ган-Өлзий | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөгжүүлэлтийг тогтмол хийх. | | | |
| 6 | Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5. | - Шалгуур үзүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулсан байх,<br>- Хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байх,<br>- Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн байх. | XII/01 | Ц.Энхцэцэг | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |
| .7 | Компаний бүтцийн нэгж дэх ажлын байр, албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн, АТГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж хянуулах ажлыг зохион байгуулах Үүнд:<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5. | - Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч, бүртгэх,<br><br>- АТГ-т хүргүүлэн хянуулах,<br>- АТГ-ын дүгнэлтийг үндэслэн томилох шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах. | V-XII сар | Ц.Энхцэцэг<br><br>Б.Тоймбаяр, О.Ганболд, Ч.Ануударь, | АТГ, |
| .8 | Мэдүүлэг гаргагч албан хаагчдаас томилогдсоноос хойш 30 хоногт (2016*) багтаан ХАСХОМ-ийг мэдүүлэх ажлыг зохион байгуулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3. | - Байгууллагын мэдүүлэг гаргагч эрх бүхий ажилтан, удирдах ажилтнууд (шинээр томилогдсон) ХАСХОМ-ээ хугацаанд нь гаргаж мэдүүлсэн байх,<br>- Цахим системд баталгаажуулсан байх,<br>- ЭБАТ-д цаасан сууриар мэдүүлгийг хүлээлгэж өгсөн ХАСХОМ-ын бүртгэлийг цахим системд оруулах,<br>- Мэдүүлэг бүрдүүлэлтийн ажил цаг хугацаандаа зохион байгуулагдсан, зөрчилгүй байх. | V-XII сард | Ц.Энхцэцэг | Эрх бүхий ажилтан, удирдах ажилтнууд /жагсаалтын дагуу/ |
| .9 | Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг холбогдох албан хаагчдаас гаргуулан авч, бүртгэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын | - Холбогдох албан хаагчдаас мэдэгдлийг тухай бүр гаргуулан авах,<br>- Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдэгдлийн мэдээллийг бүртгэн оруулсан байх,<br>- Мэдээллийн санг үүсгэн хяналт тавьж ажиллах. | V-XII сард | Ц.Энхцэцэг | Үнэлгээний хороо, Ажлын хэсэг, Шалгалтын комисс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8,6. | | | | |
| 10 | Мэдүүлэг бүрдүүлэлтийн программ дахь "ЭБАТ" цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөн мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч, ажилчдад холбогдох зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5. | - Хуульд заасан хугацаанд бүртгэл, бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байх,<br>- Мэдүүлэг гаргагч албан хаагчдад хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт (2016+)-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх талаар санамж өгөх,<br>- Заавар, зөвлөмжийг холбогдох албан хаагч бүрт хүргэж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах. | V-XII сард | Ц.Энхцэцэг | - |
| 11 | Давхар ажил эрхлэлтийн судалгаа авах, АТГ-аас ХАСУМ хянахдаа давхар ажил эрхэлж байгаа байдалд хязгаарлалтын арга хэмжээ авах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл. | - Хуулийн холбогдох заалтыг албан хаагчдад таниулан сануулах,<br>- Судалгааг бичгээр авах.<br>- Дүгнэлт хийж, удирдлагад танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авах. | IX-X сард | Б.Тоймбаяр,<br>О.Ганболд,<br>Ч.Ануударь | Нийт ажилчид |
| 12 | Авлигатай тэмцэх газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэл хөтлөн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2. | - Бүртгэлээр хяналт тавих,<br>- Удирдлагуудад танилцуулан хэрэгжилтийг хангах,<br>- Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцон холбогдох байгууллага, удирдлага, олон нийтэд танилцуулах. | V-XII сард | Ц.Энхцэцэг,<br>А.Оюунцэцэг | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба, |
| 13 | Хамаарал бүхий этгээд бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн судалгааг гаргах | - Хүний нөөцийн судалгааг гаргах<br>- Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн | | Б.Батцэцэг,<br>Ц.Энхцэцэг, | ХҮА |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 17 дугаар зүйлийн 17.5, 20 дугаар зүйлийн 20.3. | судалгааг гаргах<br>- Хамаарал бүхий этгээд бусад нэгдмэл сонирхолтой этгээдийн судалгааг нэгтгэн гаргах удирдлагуудад танилцуулах. | | Б.Тоймбаяр, О.Ганболд, Ч.Ануударь | |
| 14 | Худалдан авах ажиллаганы ил тод байдлыг хангаж, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэлийг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/, хуудсанд тодорхой байршуулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5. | - Цахим хуудсанд тендерийн үр дүнг мэдээлэхдээ ЗХНХ-ээр урьдчилан хянуулсны дүнд олон нийтэд мэдээлэх,<br>- Цахим хуудаснаас мэдээллийг тодорхой авах боломжтой байх. | V-XII сард | Ц.Энхцэцэг, Үнэлгээний хороо, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар | ХҮА |
| 15 | Зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөллийг оролцуулж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;<br>• Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5. | - Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах урилгыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн байх,<br>- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээний төслийг цахим хуудсанд байршуулах,<br>- Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалт тусгах,<br>- Гэрээ байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулах,<br>- Мэдээллийн бааз үүсгэсэн байх. | V-XII сард | Ц.Энхцэцэг, Ц.Зоригтбаатар | МТХ |
| 16 | Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, | - Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг | V-XII сард | А.Оюунцэцэг | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;<br>• Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8, 7.9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг. | бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр),<br>- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах<br>- Улирлын мэдээ гаргаж, шийдвэрлэлтийн байдлыг улирлаар мэдээлсэн байх,<br>- Цахим хуудсанд байршуулан мэдээлэх. | | | |
| 17 | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр (тушаал, тогтоол)-ийг цахим хуудсанд байршуулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5. | - Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх (цахим хуудсаар),<br>- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт), дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх. | IX-XII сард | Г.Ган-Өлзий, О.Далай, А.Оюунцэцэг, Г.Пүрэвдорж | МТХ, Г.Ган-Өлзий, Нэгжүүдийн ДАХМ, Хуулийн мэргэжилтнүүд |
| 18 | Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3. | - ТББ-ын үйл ажиллагааг дэмжих,<br>- Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга (уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м)-д нэгдэх. | Тухай бүр | Ц.Энхцэцэг | Бүх салбар, нэгж, хэлтэс, алба |
| 19 | Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах,<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай | - Судалгааны үндсэн дээр эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргах,<br>- Албан хаагчдаас санал авах,<br>- Тушаалаар батлан гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлэх. | X сард | Б.Тоймбаяр, Г.Ган-Өлзий, О.Далай | Г.Ган-Өлзий, Ч.Мядагмаа, Б.Тоймбаяр, О.Ганболд, Ч.Ануударь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1. | | | | |
| 20 | Ажилчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6. | - Албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх,<br>- Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй мэдээлсэн байх. | V-VI сард | Б.Тоймбаяр | ХААХ, МТХ, Ч.Мядагмаа, Б.Тоймбаяр, О.Ганболд, Ч.Ануударь |
| 21 | Компаний үйл ажиллагааны хангах, түгээх, нийтлэгийн чиглэлээр батлагдсан журмыг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8. | - Хангах болон түгээх, нийтлэгийн чиглэлээр баталсан журмыг цахим хуудсандаа байршуулах,<br>- Техникийн нөхцөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | V-XII сард | Б.Мөнхболд, Н.Төрболд, Г.Ган-Өлзий, Т.Батцэцэг, Ц.Энхсайхан | МТХ, |
| | **Хоёр. Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:** | | | | |
| .1 | Шинэ ажилтны сургалт, албан тушаал жинхлэх сургалт болон холбогдох бусад сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах талаар тусгах арга хэмжээг авах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1.8. | - Сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах талаар тодорхой заалт оруулж батлах асуудлыг шийдвэрлүүлэх. | XI сард | Н.Баасанжаргал, Д.Саранчимэг, Б.Мөнхзаяа | АТГ, Эрчим хүчний яам, ТӨБЗГазар |
| .2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар Үнэлгээний хороонд ажиллах ТББ-ын төлөөллүүдэд семинар өгөх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8. | - Семинарын хөтөлбөр боловсруулж батлуулах,<br>- Нэгдсэн семинар зохион байгуулах,<br>- АТГ-аас дэмжлэг авах. | XII сард | Ц.Энхцэцэг | ХААХ, ХУА |
| .3 | Нийт ажилчдын авлигын эсрэг хууль тогтоомж, мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, | - Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтох,<br>- Сургалтад нийт ажилчдыг хамруулсан байх. /Сургалтыг удирдах албан тушаалтан болон бусад гэж хоёр ангилан зохион байгуулах/ | X сард | Ц.Энхцэцэг | АТГ-ын УССГХ, ХШДШХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8. | | | | |
| .4 | Шударга ёс, ёс зүйн асуудал хөндсөн сэдвээр лекц уншуулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8. | - Лекторыг сонгон холбогдож, лекц унших товыг тогтох,<br>- Шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж, шийдвэрлүүлэх<br>- Лекцийг тогтсон хугацаанд уншуулах,<br>- Нийт ажилчдыг хамруулсан байх. | XI сард | Ц.Энхцэцэг | Ёс зүйн хороо |